



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2026.06.19 № 01/7604

танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Н.НАРАНБААТАР ТАНАА

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2.13 дахь заалтад “Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайлан, өрийн удирдлагын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг Төсвийн байнгын хороо жил бүр” гэж заасны дагуу Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг боловсруулан хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: хуудастай

Хүндэтгэсэн,



Э.МЭНДСАЙХАН

9761001084

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2023-2025
ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГИЙН
ТАЙЛАН

1. ӨМНӨТГӨЛ

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдөр “Засгийн газрын өрийн зохистой түвшнийг хангах, дунд хугацааны өрийн удирдлагын стратегийг хэрэгжүүлэх, өр үүсгэх, Засгийн газрын өрийн баталгаа гаргахтай холбогдсон харилцааг зохицуулах” зорилготой Өрийн удирдлагын тухай хуулийг баталсан.

Өрийн удирдлагын тухай хуульд Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийг бодлогын баримт бичгээр тодорхойлохоор заасан ба хуулийн 13.1-д өрийн удирдлагын стратегийн зорилгыг “макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, Засгийн газрын санхүүгийн хэрэгцээг боломжит эрсдэлийн түвшинд, хамгийн бага зардлаар санхүүжүүлэх, Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжихэд чиглэнэ” гэж тодорхойлсон байдаг.

Өрийн удирдлагын тухай хуулийн 14.2-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн баримт бичгийг боловсруулж, тухайн төсвийн жилийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хамт гурван жилд нэг удаа Төсвийн тухай хуулийн 8.1-д заасан цаглабарын дагуу батлуулна” гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2022 оны 26 дугаар тогтоолоор “Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг”-ийг баталсан.

Стратегийн баримт бичигт дунд хугацаанд өрийн удирдлагын чиглэлээр баримтлах үндсэн 6 зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ болон Засгийн газрын өрийн багцын зорилтот бүтцийн хувьд 4 шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшнийг тодорхойлсон. Үүнд дахин санхүүжилт хийхээс өөрөөр арилжааны нөхцөлтэй гадаад зээллэг хийхээс татгалзах, Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг тогтмолжуулах бэлтгэл ажлыг хангах, Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, зээлийн төлбөрүүдийг эдийн засаг төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах, Засгийн газрын өрийн баталгааг стратегийн томоохон төслүүдэд гаргах, өрийн ил тод байдлыг сайжруулах бодлогыг баримтлахаар заасан.

Сангийн яамны зүгээс Өрийн удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т “Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг гурван жилд нэг удаа гаргаж, энэ хуульд заасны дагуу Улсын Их Хуралд хүргүүлэх” гэж заасныг үндэслэн энэхүү тайланг боловсруулан тайлагнаж байна.

2. ӨРИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1 Улсын нийт гадаад өр

Өрийн удирдлагын хуулийн 4.1.4-т “улсын нийт гадаад өр”-ийг Засгийн газар, орон нутаг, Монголбанк болон Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжийн харьяат бус аливаа этгээдэд төлөх төлбөрийн үүрэг гэж тодорхойлсон. Монголбанк болон Сангийн яам хамтран улсын нийт гадаад өрийг Олон Улсын Валютын сан /ОУВС/-ийн статистик боловсруулах 6 дугаар гарын авлагыг үндэслэн “Монгол Улсын төлбөрийн тэнцлийг боловсруулах аргачлал”-ыг боловсруулж, энэ хүрээнд мэдээлэл түгээх ерөнхий шаардлагын дагуу 2010 оноос эхлэн олон нийтэд мэдээлж байна.

Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2025 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 40.5 тэрбум ам.доллартой тэнцэж байгаагаас Засгийн газрын гадаад өр 8.7 тэрбум ам.доллар (21.6%), Төв банкны гадаад өр 1.1 тэрбум ам.доллар (2.7%), бусад салбаруудын өр 8.5 тэрбум ам.доллар буюу (21.0%), Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллагын өр 4.0 тэрбум ам.доллар буюу (9.9%) байгаа бол компани хоорондын зээллэг 18.1 тэрбум ам.долларыг (44.8%) тус тус эзэлж байна.

Хүснэгт № 1. Улсын нийт гадаад өрийн статистик, 2023-2025 онд /сая ам.доллар/

Салбарын ангилал	2023 он	2024 он	2025 он
Засгийн газар	8,105.1	8,397.1	8,748.0
Төв банк	1,784.8	1,086.3	1,084.9
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	1,733.2	2,601.8	4,021.7
Бусад салбарууд	7,865.8	7,897.9	8,491.8
Компани хоорондын зээллэг, шууд хөрөнгө оруулалт	15,080.6	17,254.3	18,113.8
Нийт гадаад өр	34,569.5	37,237.4	40,460.2

Эх сурвалж: Монголбанк

2.1 Засгийн газрын өрийн өнөөгийн нөхцөл байдал

Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 2025 оны жилийн эцсийн байдлаар 35,407.6 тэрбум төгрөг, нэрлэсэн үнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа 39.4 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт № 2. Засгийн газрын өр, 2023-2025 он, тэрбум.төгрөг

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2023 он	2024 он	2025 он
1. Засгийн газрын дотоод өр	234.1	400.5	688.5
1.1. Үнэт цаас	234.1	400.5	688.5
2. Засгийн газрын гадаад өр	30,274.6	30,292.9	32,040.5
2.1. Үнэт цаас	9,371.7	8,655.0	8,964.7
2.2. Зээл	20,902.9	21,641.6	23,075.9
3. Бусад өр төлбөр	264.8	2,702.7	2,678.6

3.1. Засгийн газрын өрийн баталгаа	29.5	178.0	165.7
3.2. Орон нутгийн өр	4.5	2,524.7	2,512.9
3.3. Концесс (“барих-шилжүүлэх”)	230.9	-	-
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)	30,773.5	33,399.9	35,407.6
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	26,582.9		
Төсвийн тогтвортой байдлын тухай тогтоосон өрийн хязгаар	65.0%	60.0%	60.0%
Засгийн газрын өр / ДНБ	43.7%	41.8%	39.4%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	37.7%		

Эх сурвалж: Сангийн яам

2.2.1 Дотоод үнэт цаас

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны баримт бичгийн Зорилт 4-т “Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна.” гэж тусгасан. Үүний дагуу 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлүүлэн хоёр долоо хоног бүр нээлттэй хэлбэрийн арилжааг Монгол хөрөнгийн биржтэй хамтран bond.mse.mn платформоор дамжуулан хийсээр байна. Энэ платформоор дамжуулан арилжааг хийснээр арилжаа бүрийн мэдээллийг цаг алдалгүй авах, арилжааны үр дүнтэй хураангуй байдлаар танилцах, үнэт цаасны хуваарилалт автоматаар хийгдэх зэрэг ач холбогдолтой байна.

Нээлттэй хэлбэрээр арилжаалсан үнэт цаасны нэг жил хүртэлх буюу богино хугацаат үнэт цаас 41.0%-ийг эзэлж байгаа бөгөөд хүүгийн түвшин дунджаар 9.3%, 2-5 жил буюу дунд хугацаат үнэт цаас 56.5%-ийг эзэлж байгаа бөгөөд хүүгийн түвшин дунджаар 10.8%, 7 жил буюу урт хугацаат үнэт цаас 2.5%-ийг эзэлж байгаа бөгөөд хүүгийн түвшин дунджаар 13.3% байна. Энэ нь хөрөнгийн зах зээл дэх жишиг хүү тогтоох, цаашлаад хөрөнгийн зах зээлийг дэмжиж буй явдал юм.

График 1. Засгийн газрын дотоод үнэт цаасны өгөөжийн муруй /2025.12.31-ний байдлаар/





График 2. Арилжааны санал /тэрбум ₮/



ЗГДҮЦ-ны нээлттэй арилжааг эхлүүлснээр дотоодын зах зээлд төгрөгийн эрсдэлгүй өгөөжийн муруйг тогтоон, аж ахуйн нэгжүүдийн дотоодын зах зээлээс төвлөрүүлэх эх

үүсвэрийн үнэлгээ бодитоор буюу харьцангуй бага хэмжээнд хүү тогтох, хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын бааз суурийг нэмэгдүүлэх ач холбогдолтой байна.

Нээлттэй хэлбэрийн 32 удаагийн арилжаагаар нийт 148.7 тэрбум төгрөгийг арилжаалсан бөгөөд 71.7%-ийг арилжааны банк, 9.9%-ийг даатгалын байгууллага, 18.5%-ийг гадаад, дотоодын иргэд, ААН эзэмшиж байна.

Улмаар 2025 оны жилийн эцсийн байдлаар 688.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 71.9%-аар нэмэгдсэн байна. Тайлант онд Засгийн газрын дотоод үнэт цаасны үйлчилгээний төлбөрт нийт 50.5 тэрбум төгрөг төлсөн. Үүнээс үндсэн төлбөрт 15.0 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 35.5 тэрбум төлбөрийг шилжүүлсэн байна.

2.2.2 Гадаад үнэт цаас

Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан гадаад бондын үлдэгдэл 2025 оны жилийн эцсийн байдлаар 8,817.5 тэрбум төгрөг байна.

Хүснэгт № 3. Гадаад үнэт цаас, тэрбум төгрөг /2025.12.31/

Гадаад үнэт цаас	Купон	Хугацаа	Үлдэгдэл /сая ам.доллар/	Хуримтлагдсан хүү /тэрбум.тогрөг/	Үлдэгдэл /бодит үнэ, face value/	Үлдэгдэл /нэрлэсэн үнэ, nominal value/
Сенчири-2	8.650%	5 жил	541.7	74.5	1,926.7	1,991.1
Сенчири 2027	3.500%	6 жил	413.1	24.7	1,469.4	1,488.4
Сенчири 2031	4.450%	10 жил	500.0	38.0	1,778.3	1,796.1
Сенчири-3	7.875%	5.5 жил	350.0	6.8	1,244.8	1,244.1
Сенчири-4	6.625%	5 жил	500.0	40.6	1,778.3	1,818.9
Номад	5.125%	5.5 жил	174.3	7.3	619.8	626.1
Нийт дүн			2,479.1	192.0	8,817.5	8,964.7

Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын зүгээс стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, дунд хугацааны төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор олон улсын зах зээлд 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр 650.0 сая ам.долларын 8.65 хувийн хүүтэй “Сенчири-2” бондыг арилжаалж 2023 онд төлөгдөх “Гэрэгэ” бонд, 2024 онд төлөгдөх “Хуралдай” бондын тодорхой хэсгийг, мөн 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 350.0 сая ам.долларын 7.875 хувийн хүүтэй “Сенчири-3” бондыг арилжаалж 2024 онд төлөгдөх “Хуралдай” бондын тодорхой хэсгийг, 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 500 сая ам.долларын хэмжээтэй, 6.625 хувийн хүүтэй “Сенчири-4” бондыг гаргаж “Номад” бонд болон “Сенчири-2” бондуудаас тодорхой хэсгийг өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд тус тус шийдвэрлэсэн.

Түүнчлэн, стратегийн хэрэгжилтийн хугацаанд “Гэрэгэ” бондын үлдэгдэл 90.8 сая ам.долларыг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр, “Хуралдай” бондын үлдэгдэл төлбөр

болох 52.9 сая ам.долларын төлбөрийг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр төрийн сангийн мөнгөн хөрөнгөөс тус тус бүрэн төлж барагдуулсан.

2.2.3 Гадаад зээл

Монгол Улсын Засгийн газар 1991 оноос Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны гишүүнээр элсэн орж, олон талт болон хоёр талт зээлдүүлэгчдээс зээл авч ашиглаж ирсэн бөгөөд нийт гадаад зээлийн үлдэгдэл 2025 оны жилийн эцсийн байдлаар 6,488.1 сая ам.доллар буюу 23,075.9 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Монгол Улсын Засгийн газар олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу 2023-2025 онд буюу Стратегийн баримт бичгийн хэрэгжих хугацаанд гадаад зээлийн үйлчилгээний төлбөрт нийт 5,166.6 тэрбум төгрөгийг төлж, үүнээс үндсэн төлбөрт 3,604.7 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 1,561.9 тэрбум төгрөгийг тус тус төлсөн.

2.2.4 Засгийн газрын өрийн баталгаа

Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2025 оны жилийн эцсийн байдлаар 165.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Энэхүү Монгол Улсын Хөгжлийн банкны 2021 онд авч ашигласан “Чойбалсан ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төсөл”-ийн санхүүжилтэд шаардагдах 420 сая юанийн зээлд 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр гаргасан Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл юм.

Хүснэгт № 6. Засгийн газрын баталгаа /2025.12.31/

№	Баталгаа гаргуулагч	Зээлдүүлэгч	Валют	Нэрлэсэн үлдэгдэл 2025 он	
				Үндсэн валют /сая/	Тэрбум төгрөг
1	Монгол Улсын Хөгжлийн банк	Хятадын хөгжлийн банк /China Development Bank/	Юань	322.7	165.7
				НИЙТ	164.7

Эх сурвалж: Сангийн яам

Түүнчлэн, Засгийн газраас Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын олон улсын зах зээлд арилжаалсан “Сэлбэ дэд төв”-ийн бүтээн байгуулалтад шаардлагатай 500 сая ам.долларын гадаад үнэт цаасны төлбөрийн үүрэгт Засгийн газрын өрийн баталгаа гаргасан бөгөөд энэхүү өр төлбөрийг орон нутгийн өр төлбөрт бүртгэж байгаа тул давхардуулахгүй байх зорилгоор Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэлд тусгаагүй.

2.2.5 Орон нутгийн өр

Засгийн газрын 2024 оны 168 дугаар тогтоолоор “Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх журам”-ыг баталсан. Үүний дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2024 онд нийт 798 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаасыг “Бөөрөлжүүтийн

ДЦС-ыг барих төсөл”, “Батарей хуримтлуурын төсөл” болон Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлийн ажил төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор гаргасан бол 500 сая ам.долларын гадаад үнэт цаасыг “Сэлбэ дэд төв”-ийн бүтээн байгуулалтад зориулж гаргаад байна.

Тайлант хугацаанд нийт 115.5 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр төлсөн бөгөөд үүнээс Улаанбаатар хотын авто, замын байгууламжийн засвар, шинэчлэлийн ажлын төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цааснаас 100.0 тэрбум төгрөгийг, Батарей хуримтлуурын станц барих зорилгоор арилжаалсан үнэт цааснаас 15.5 тэрбум төгрөгийг төлсөн байна. Ингэснээр орон нутгийн өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 2,512.9 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт № 6. Орон нутгийн үнэт цаас /2025.12.31/

№	Үнэт цаас гаргагч	Зээлдүүлэгч	Нэрлэсэн үлдэгдэл
			2025 он
			Тэрбум төгрөг
1	Нийслэлийн Засаг даргын	Дотоодын хөрөнгө оруулагч	684.7
2	Тамгын газар	Олон улсын хөрөнгө оруулагчид	1,828.1
	НИЙТ		2,512.9

Эх сурвалж: Сангийн яам

3. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАГЦЫН ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТОТ БҮТЭЦ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Зорилт 1. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, гадаад зээлийн өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулна.

1.1 Эдийн засгийн бодит өсөлт болон экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй, гадаад улс орны худалдан авалтыг дэмжих замаар импортыг өсгөж, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах нөлөө бүхий Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрийг авч ашиглахаас татгалзах;

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр 2023-2025 оны хооронд хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт туссан байдал, Өрийн удирдлагын тухай хуулийн шаардлагад нийцсэн байдал болон Засгийн газрын өрийн удирдлагын стратегийн баримт бичигтэй уялдсан төслүүдийн саналуудыг хүлээн авч Засгийн газар, Улсын Их Хуралтай зээлийн гэрээ байгуулах асуудлыг зөвшилцөн 2023 онд 553.5 сая ам.доллар, 2024 онд 681.7 сая ам.доллар, 2025 онд 635.9 сая ам.доллартой тэнцэх зээлийн хэлэлцээрүүдийг байгуулсан.

Түүнчлэн, 3.0 тэрбум ам.доллартой тэнцэх төсөл хэрэгжүүлэх хүсэлтээс 1.1 тэрбум ам.доллартой тэнцэх төсөл хэрэгжүүлэх хүсэлтүүдийг Өрийн удирдлагын тухай хуулийн шаардлагыг хангах, төслийн ашигт ажиллагаа болон зээлийн нөхцөлийн уялдааг хангах зэрэг шалтгаанаар хүлээн авах боломжгүй тул холбогдох салбар яамд руу буцаасан байна.

1.2 Өрийн удирдлагын тухай хуулийн 7.1.6-д зааснаас бусад тохиолдолд зөвхөн бодит эдийн засгийн салбарт чиглэсэн төслийг санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын гадаад зээл авч ашиглах

Стратегийн хэрэгжилтийн хугацаанд нийт 121 гадаад зээлд 4,845.3 тэрбум төгрөгийн хөрөнгийг авч ашиглаж, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн урт хугацааны баримт бичигт заасан эдийн засгийн тэргүүлэх чиглэл бүхий бодит эдийн засгийн салбарт чиглэсэн төслийг санхүүжүүлсэн байна.

Энэхүү Засгийн газрын гадаад төслийн зээлийн ашиглалтыг салбараар нь ангилвал эрчим хүчний салбарт 38.9 хувь, орон сууц, нийтийн аж ахуйн салбарт 27.2 хувь, зам тээврийн салбарт 9.6 хувь, эрүүл мэндийн салбарт 6.0 хувь, үлдсэн 18.3 хувийг бусад салбарын зээлүүд эзэлж байна.

Стратегийн тайлангийн хэрэгжилтийн хугацаанд эдийн засгийн ач холбогдол бүхий “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төсөлд 993.5 тэрбум төгрөг, “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” төсөлд 272.4 тэрбум төгрөг, “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих” төсөлд 249.5 тэрбум төгрөг, “Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуур”-ын төсөлд 257.9 тэрбум төгрөг, “УБ-Дарханы чиглэлд нэмэлт 2 эгнээ барих” төсөлд 187.7 тэрбум төгрөг, “Баянголын ам түрээсийн орон сууц барих” төсөлд 144.3 тэрбум төгрөг, “Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах” төсөлд 94.8 тэрбум төгрөг, “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний

хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн төсөлд 88.6 тэрбум төгрөг, “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах” төсөлд 81.2 тэрбум төгрөг, “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах” төсөлд 74.0 тэрбум төгрөг, “Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах автомашин нийлүүлэх” төсөлд 58.0 тэрбум төгрөг, “КОВИД-19 ийн эсрэг вакцинжуулалтын арга хэмжээг дэмжих” төсөлд 53.9 тэрбум төгрөг, “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх” төсөлд 45.7 тэрбум төгрөг, “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам”-ын төсөлд 39.7 тэрбум төгрөг, “АШУҮИС болон эмнэлгүүдийн тоног төхөөрөмж шинэчлэх” төсөлд 28.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

1.3 Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжааны нөхцөлтэй зээллэг хийхгүй байх;


Засгийн газраас 2023-2025 оны хооронд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжааны нөхцөлтэй зээллэг авч ашиглаагүй байна.

Зорилт 2. Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.

2.1 Гадаад зах зээлийн нөхцөл байдал, зардал, эрсдэлийн судалгааг тогтмол хийж, Засгийн газрын гадаад үнэт цаасыг хугацаанаас нь өмнө худалдан авах арга хэмжээг хэрэгжүүлэх,

Монгол Улсын Засгийн газрын олон улсын зах зээлд гаргасан үнэт цааснуудын хоёрдогч зах зээл дэх үнэ, өгөөжийн судалгааг тогтмол хийж тухайн үнэт цааснуудын үнэ анх гаргасан үнээс бага болж, буцаан худалдан авах хэмжээ хуваарьт хугацаанд төлөх хэмжээнээс бага болсон “цонх” үед буцаан худалдан авах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Тухайлбал, 2023 онд “Номад” үнэт цаасны хоёрдогч зах зээлийн үнэ нэрлэсэн үнээс доогуур байсан тул нийт 22.0 сая ам.долларын нэрлэсэн үнэтэй үнэт цаасыг 21.4 сая ам.доллараар, 2024 онд “Номад”, “Сенчири-1” үнэт цааснуудын нийт 98.9 сая ам.долларын нэрлэсэн үнэтэй үнэт цаасыг 91.2 сая ам.доллараар тус тус буцаан худалдан авч үнэт цаасны нэрлэсэн дүнгээс төсөвт нийт 8.3 сая ам.долларын хэмнэлтийг үүсгээд байна.



2.2 Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг мөнгөн хөрөнгийн хуримтлалаас боломжит хэмжээгээр төлөх, өрийн зохицуулалтын арга хэмжээ, хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр 650.0 сая ам.долларын “Сенчири-2” үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалж “Гэрэгэ” болон “Хуралдай”

бондоос, 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 350.0 сая ам.долларын “Сенчири-3” үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалж “Хуралдай” бондоос, 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 500.0 сая ам.долларын “Сенчири-4” үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалж “Номад”, “Сенчири-2” бондуудын төлбөрөөс тодорхой хэсгийг тус тус дахин санхүүжүүлсэн байна.

Ингэснээр 2023-2025 онд төлбөрийн хуваарийн дагуу төлөгдөх байсан “Тэрэгэ” бондоос 442.3 сая ам.долларын төлбөрийг дахин санхүүжүүлж, 90.8 сая ам.долларын төлбөрийг төрийн сангийн мөнгөн хөрөнгөөс санхүүжүүлсэн байна. “Хуралдай” бондоос 547.1 сая ам.долларын төлбөрийг дахин санхүүжүүлсэн бол 52.9 сая ам.долларыг, “Сенчири-1” бондоос 86.9 сая ам.долларыг төсвийн мөнгөн хөрөнгөөс төлсөн бол “Номад” бондоос 391.7 сая ам.долларын төлбөрийг, “Сенчири-2” бондоос 108.3 сая ам.долларын төлбөрийг тус тус дахин санхүүжүүлсэн байна. Ингэснээр нийт 1,489.4 тэрбум төгрөгийг дахин санхүүжилтээр төлсөн бол 230.6 сая ам.долларын төлбөрийг төсвийн мөнгөн хөрөнгөөс санхүүжүүлсэн байна. Ингэснээр төлбөрийн тэнцэл, төсвийн тэнцэл, гадаад валютын албан нөөцөд учирч байсан дарамтыг бууруулсан байна.

2.3 Дахин санхүүжилтээс бусад зориулалтаар Засгийн газрын гадаад үнэт цаасыг арилжаалахгүй байх;

Засгийн газраас стратегийн хэрэгжилтийн хугацаанд нийт 1.5 тэрбум ам.долларын хэмжээтэй гадаад үнэт цаасыг зөвхөн дахин санхүүжилтийн зориулалтаар гаргасан бөгөөд бусад зориулалтаар гадаад үнэт цаас арилжаалаагүй байна.

2.4. Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах үүднээс зэрэглэл тогтоогч байгууллага, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр тогтмол ханган хамтарч ажиллах

Засгийн газрын зүгээс стратегийн хэрэгжилтийн хугацаанд зээлжих зэрэглэл тогтоогч агентлагууд болон Засгийн газрын гадаад үнэт цаасны хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн хариуцлагын хүрээнд Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын төлөв байдлын талаарх мэдээг тухай бүр хүргэж байна. Засгийн газрын гадаад үнэт цаасны эргэн төлөлтүүдийг хугацаанд нь төлснөөр олон улсын санхүүгийн зах зээл дээрх нэр хүнд, хөрөнгө оруулагчдын итгэлийг алдалгүй ажиллаж байна.

Монгол Улсын 2025 оны зээлжих зэрэглэлийг Фитч агентлагаас “В+, тогтвортой”, Эс энд Пи агентлагаас “ВВ-, тогтвортой”, Мүүдис агентлагаас “В1, тогтвортой” төлөвтэй болгож ахиулсан. Монгол Улсын зээлжих зэрэглэлийг шинэчлэн тогтоолгох ажлын хүрээнд Эс энд Пи, Фитч, Мүүдис агентлагуудад Монгол Улсын төсөв, санхүү, макро эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын төлөвийн талаарх мэдээллийг тус байгууллагуудтай байгуулсан гэрээний дагуу жилийн эцэс болон хагас жилийн мэдээллийг тогтмол хүргүүлдэг бөгөөд жилд нэг удаагийн уулзалтыг зохион байгуулж зээлжих зэрэглэлийн үнэлгээг хийлгэдэг.

Зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагад зориулан зохион байгуулсан арга хэмжээ, өгсөн мэдээлэл:

1. Эс энд Пи агентлаг нь Монгол Улсын зээлжих зэрэглэлийн 2024 оны үнэлгээг хийхтэй холбоотойгоор 2024 оны 08 дугаар сарын 13-14-ны өдрүүдэд Монгол Улсад ирж, холбогдох төрийн болон олон улсын байгууллагууд, хувийн хэвшлийн төлөөллүүдтэй уулзалт хийж ажилласан. Үүний дараагаар 2025 онд дахин үнэлгээ хийж 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр ирж уулзалт зохион байгуулсан бөгөөд үүнд шаардлагатай мэдээллийг гаргаж өгсөн.
2. Фитч агентлаг нь 2024 онд Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг 2 удаа хийхээр мэдэгдсэн. Энэ хүрээнд эхний үнэлгээг 2024 оны 01 дүгээр сард цахим хурлаар зохион байгуулан үнэлж, Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "В/тогтвортой" хэвээр хадгалж буйгаа 2024 оны 02 дугаар сарын 2-ны өдөр зарласан. Фитч агентлагийн 2024 оны 2 дахь үнэлгээг 2024 оны 09 дүгээр сарын 2-3-ны өдөр Монгол Улсад ирж холбогдох байгууллагуудтай уулзаж, шинээр байгуулагдсан Монгол Улсын засгийн газрын хөгжлийн төлөвлөгөө болон макро эдийн засаг, төсөв санхүүгийн мэдээлэл авч ажилласан ба улмаар Монгол Улсын 2024 оны зээлжих зэрэглэлийн үнэлгээг "В+, тогтвортой" болгон сайжруулснаа 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр танилцуулсан бөгөөд үүнийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр хэвээр хадгалсан.
3. Мүүдис агентлагийн хувьд Монгол Улсын зээлжих зэрэглэл "В3", төлөв "Тогтвортой" байгаа нөхцөлд 2 жилд нэг удаа зээлжих зэрэглэлийн шийдвэрийг гаргадаг. Харин Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлын талаарх тайланг жилд 2 удаа нийтлэн ажиллаж байна. Энэ хүрээнд Мүүдис агентлаг нь 2024 оны 02 дугаар сарын 12 өдөр болон 8 дугаар сарын 27-ны өдөр тус тус гаргасан ба ингэхдээ Монгол Улсын Засгийн газраас цахимаар мэдээлэл авч ажилласан. Үүний дараагаар Мүүдис агентлаг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсад ирж дахин үнэлгээ хийсэн бөгөөд үүнд шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгч ажилласан.

Түүнчлэн, Засгийн газраас хөрөнгө оруулагчидтай тогтмол уулзалт зохион байгуулж, олон улсын зах зээлд үнэт цаас гаргах, санхүүжилт татах боломжийг үргэлж нээлттэй байлгах тал дээр анхаарч ажиллаж байна. Тухайлбал, 2023 онд гаргасан "Сенчири-2" болон "Сенчири-3", "Сенчири-4" үнэт цаасны хүрээнд хөрөнгө оруулагчидтай уулзалт зохион байгуулж, Монгол Улсын эдийн засаг, улс төр, төсвийн мэдээллийг тогтмол өгч ажилласан бол 2023 оны 06 дугаар сар, 2024 оны 07 дугаар саруудад олон улсын хөрөнгө оруулагчидтай биетээр уулзаж мэдээлэл өгсөн. Мөн цахимаар тогтмол мэдээлэл хүргүүлдэг бөгөөд бусад хөрөнгө оруулагчдад зориулж Сангийн яамны цахим хуудсанд тогтмол Засгийн газрын өрийн мэдээллийг байршуулж байна. Түүнчлэн, дараах мэдээллийг Монгол Улсад байгаа хөрөнгө оруулагчдад зориулж мэдээлэл хүргүүлж байна. Үүнд:

Хөрөнгө оруулагчдад зориулан зохион байгуулсан арга хэмжээ, өгсөн мэдээлэл:

1. Засгийн газрын гадаад хөрөнгө оруулагчдад тогтмол мэдээлэл хүргэн ажиллах хүрээнд Citi болон Deutsche олон улсын хөрөнгө оруулалтын банкнуудтай хамтран “Хөрөнгө оруулагчдын уулзалт”-ыг Монгол Улсад 2024 оны 6-8 дугаар саруудад зохион байгуулан ажилласан. Хөрөнгө оруулагчдын уулзалтад нийт 15 хөрөнгө оруулагчид хамрагдаж төрийн болон олон улсын байгууллагуудтай уулзаж Монгол Улсын эдийн засаг, төсөв санхүүгийн мэдээллийг авсан.
2. Сангийн яамны төлөөлөгчид J.P.Morgan олон улсын хөрөнгө оруулалтын банкнаас жил бүр зохион байгуулдаг “Хөгжиж буй зах зээлийн хөрөнгө оруулагчдын форум”-д 2024 оны 09 дүгээр сарын 16-19-ны өдрүүдэд Лондон хотноо оролцож 70 гаруй хөрөнгө оруулагчидтай уулзаж, Монгол Улсын эдийн засаг, цаашдын төлөв, Засгийн газрын бодлогын талаар мэдээлэл өгч ажилласан.
3. Засгийн газраас 2025 оны 07 дугаар сард хөрөнгө оруулагчдад шаардлагатай мэдээллийг өгч “Сенчири-4” бонд гарснаас хойш эдийн засаг, төсвийн байдал хэрхэн өөрчлөгдсөн талаар мэдээллийг өгөх зорилгоор олон улсын цахим хурлыг 5 хоногийн турш хийж мэдээллийг өгсөн. Ингэхдээ эдийн засгийн гүйцэтгэл, төсвийн гүйцэтгэл, мөнгөний бодлого, санхүүгийн салбарын нөхцөл байдал, хэрэгжиж буй томоохон төслүүдийг мэдээлж, ирсэн асуултуудад хариулт өгсөн. Ингэхэд Ази, Европ, Америк тивээс хөрөнгө оруулагчид оролцож хөрөнгө оруулах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.

Зорилт 3. Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор үүсмэл арга хэрэгслийг өрийн зохицуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

3.1 Засгийн газрын хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр Монголбанктай хамтран ажиллас, гадаад өрийн үйлчилгээний хуваарийг валютын нөөцтэй уялдуулах, шаардлагатай тохиолдолд валют болон хүүгийн своп хэлэлцээрийг зээлдүүлэгч талтай хийх;

Засгийн газраас 2023-2024 оны хооронд гадаад өр төлбөрийг бууруулах, боломжит хэмжээгээр төрийн сангийн мөнгөн хөрөнгөөс төлөх, ингэхдээ Монгол Улсын гадаад валютын албан нөөцтэй уялдуулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Үүнд:


1. Засгийн газрын гадаад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн үнэ анх гаргасан үнээс бага байгаа үед буюу 2023 оны 10 дугаар сард “Номад” бондын төлбөрөөс 22 сая ам.долларын нэрлэсэн үнэтэй бондыг, 2024 оны 10-12 дугаар сард “Номад”, “Сенчири-1” бондуудын төлбөрөөс 98.9 сая ам.долларын нэрлэсэн үнэтэй бондыг тус тус буцаан худалдан авсан.

2. Засгийн газраас “Хуралдай” бондын үлдэгдэл төлбөр болох 169 сая ам.долларыг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр, “Гэрэгэ” бондын үлдэгдэл төлбөр болох 368.4 сая ам.долларыг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр тус тус төлж барагдуулсан. Энэхүү 2024 оны 03 дугаар сард төлсөн 169 сая ам.долларын төлбөрийн 116 сая ам.доллар нь 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр олон улсын зах зээлд гаргасан Сенчири-3 бондын үлдэгдэл байсан бол 2023 оны 04 дүгээр сард төлсөн 368 сая ам.долларын төлбөрийн 278 сая ам.доллар нь 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр гаргасан “Сенчири-2” бондын үлдэгдэл байсан. Ингэснээр “Гэрэгэ”, “Хуралдай” бондын үлдэгдэл төлбөр болох 144 сая ам.долларын төлбөрийг төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс төлж барагдуулсан болно.
3. Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр олон улсын зах зээлд гаргасан “Сенчири-2” бондын хөрөнгөөр “Гэрэгэ”, “Хуралдай” бондуудын төлбөрийг дахин санхүүжүүлэх төлөвлөгөөтэй байсан боловч хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтаас шалтгаалан 278 сая ам.долларыг ашиглах боломжгүй болж, Төв төрийн санд хуримтлагдсан. Энэхүү хөрөнгийг төрийн санд хадгалах нь өгөөжгүй бөгөөд хадгалагдах хугацаанд “Сенчири-2” бонд болон “Гэрэгэ” бондын хүүгийн төлбөр зэрэг бодогдож байсан тул тус мөнгөн хөрөнгийг Монголбанктай хамтран гаднын төв банканд хүүтэй хадгалуулах шийдвэрийг гаргасан.
Ингэснээр Сангийн сайдын 2023 оны “Богино хугацаат санхүүгийн хөрөнгө оруулалт хийх тухай” 20 дугаар тушаалыг үндэслэн Төв төрийн санд төвлөрсөн 300 сая ам.долларыг Францын төв банканд 4.75 хувийн хүүтэйгээр байршуулсан. Энэхүү хөрөнгө оруулалтыг 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 04 дүгээр сарын 03-ны өдрийг хүртэл хадгалж хүүгийн орлогод 2.3 сая ам.долларыг төвлөрүүлсэн.
4. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх хэсэгт “Ирээдүйн өв сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор хуримтлуулах, хуримтлагдсан хөрөнгийг олон улсын зах зээлийн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар өнөөгийн үнэ цэнийг өсгөх, арвижуулах” гэж, мөн дээр дурдсан хөрөнгийн удирдлагын бодлогын 2.1-д “Сангийн хөрөнгийг найдвартай, хөрвөх чадвартай байх нөхцөлийг зэрэг хангасны үндсэн дээр эрсдэл-өгөөжийн зохистой түвшнийг баримтлан удирдана” гэж тус тус заасны дагуу “Ирээдүйн өв сангийн хөрөнгөөс төв банканд гадаад валютаар хадгаламж байршуулах гэрээ”-г 2025 оны 03 сарын 07-ны өдөр, “Ирээдүйн өв сангийн хөрөнгөөс Төв банканд гадаад валютаар хадгаламж байршуулах гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ”-г 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр тус тус Монголбанктай байгуулсан. Дээрх гэрээний дагуу Ирээдүйн өв сангийн хөрөнгийг Монголбанкны харилцагч Англи, Франц болон Люксембург улсуудын төв банкнуудад хуваан дунджаар 3.7-4.4 хувийн хүүтэйгээр хадгаламж хэлбэрээр байршуулснаар 2025 онд нийт 40.4 сая ам.доллар буюу 144.3 тэрбум төгрөг, 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 13.3 сая ам.доллар буюу 47.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын орлого тус тус санд төвлөрсөн.

3.2 Дэлхий нийтэд тулгараад байгаа инфляцын өсөлтөөс шалтгаалан гадаад зах зээлд бий болоод байгаа хүүгийн өсөлтөөс хамааран урт, дунд хугацаанд Засгийн газрын гадаад зээлийн хөвөгч хүү өсөх тохиолдолд тогтмол хүүтэй зээл авах нөхцөлийг зээлдүүлэгч талд тавьж ажиглах

Олон улсын эдийн засаг 2020 оноос хойш КОВИД-19 цар тахал, геополитикийн мөргөлдөөн буюу ОХУ болон Украины хурцадмал байдал, Дундад Азид гарч буй мөргөлдөөн болон дэлхий нийтэд тулгараад буй инфляцын өсөлт зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалж хөгжингүй орнууд бодлогын хүүгийн түвшнээ өсгөж эхэлсэн. Үүнээс шалтгаалж Монгол Улсын Засгийн газрын гадаад зээлийн хүүгийн жишиг болгон авдаг Баталгаат овернайт санхүүжилтийн түвшин (SOFR/COФР) өсөж түүхэн дээд түвшиндээ ирсэн. Дараах графикаар СОФР хүүгийн түвшний түүхэн хэмжээг харуулав.

График 3. Баталгаат овернайт санхүүжилтийн хүүгийн түвшин, хувь, 2020-2025 он



Түүнчлэн, Монгол Улсын хувьд 1991 оноос 2010 оны хооронд нэг хүнд ногдох Үндэсний нийт орлого 1,005 ам.доллараос бага тул бага-орлоготой орны ангилалд байсан бол 2011 онд тус үзүүлэлт 1,890 ам.долларт хүрч, бага дундаж орлоготой орны шалгуурыг хангасан бөгөөд 2023 оны байдлаар нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын хэмжээ 4,950 ам.долларт хүрсэн тул дунджаас дээгүүр орлогын ангилалд (Upper middle income) хамаарч байна.

Үүнээс шалтгаалан Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас зээлдүүлэх зээлийн нөхцөл хөнгөлөлттэй нөхцөлөөс арилжааны нөхцөл рүү шилжиж байна. Тухайлбал, Монгол Улсын хамгийн томоохон зээлдүүлэгчийн нэг болох Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкнууд зэрэг олон улсын байгууллагуудаас Монгол Улсад олгох нэн

хөнгөлөлттэй эх үүсвэрийн хөнгөлөлтийг бууруулж, хөнгөлөлттэй эх үүсвэр болон энгийн эх үүсвэрийг холимог байдлаар олгож эхэлсэн.

Засгийн газрын хувьд 2023-2025 оны хооронд нийт 1,836.8 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн гэрээ байгуулсан бөгөөд үүнээс 1,140.1 сая ам.доллар буюу 62.1 хувийг тогтмол хүүтэй нөхцөлөөр авсан.

3.3 Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн төсөл, арга хэмжээг дэмжснэ, тэдгээрийн санхүүжилтийг Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн өрийн хэрэгсэлтэй уялдуулж, Засгийн газрын өрийн зохицуулалтын арга хэмжээнд нэвтрүүлэх боломжийг судалж, бэлтгэл ажлыг хангуулахад холбогдох яамтай хамтран ажиллах, түүнчлэн эдгээр арга хэмжээний ач холбогдлыг олон нийтэд таниулах;

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Монгол Улсын тогтвортой хөгжил, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтөд чиглэсэн санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Тогтвортой Хөгжлийн Зорилтуудтай нийцсэн бондын баримт бичгийг 2023 онд боловсруулж Эс энд Пи олон улсын зээлжих зэрэглэлийн агентлагаар 2023 оны 1-р улиралд хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлсэн. Хөндлөнгийн үнэлгээгээр тус баримт бичиг нь олон улсын зарчмуудыг хангасан гэж үнэлэгдсэн бөгөөд тус үнэлгээ нь Эс энд Пи агентлагийн цахим хуудсанд 2023 оны 06 дугаар сард нийтлэгдсэн. Дээрх санхүүгийн шинэлэг хэрэгслийн ач холбогдлыг олон нийтэд таниулах ажлын хүрээнд холбогдох сургалт, хэлэлцүүлгийг 2024 оны 05 дугаар сард зохион байгуулж цаашид олон улсын зах зээлд арилжаалах бэлтгэл ажлыг хангасан.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газар Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголт, зээлийн банк (KfW) болон Глобаль сантай хамтран өр хөрвүүлэх арга хэмжээний хэлэлцээрийг хийж Засгийн газраас Герман улсад төлөх 29 сая евротой тэнцэх хэмжээний төлбөрийн үүргийг буцалтгүй тусламжийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хөрвүүлэх хэлэлцээрт 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр гарын үсэг зурсан. Энэхүү хэлэлцээрийг хийснээр Монгол Улсын Засгийн Газар Герман Улсын KfW банканд төлөх өр төлбөрөөс 29.0 сая еврогийн дүнтэй тэнцэх төлбөрийг Монгол Улсад хэрэгжих ДОХ, гепатит, сүрьеэ өвчний эсрэг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт чиглүүлэх боломж бүрдэх юм.

Тус хэлэлцээрийн хүрээнд Герман улсад 2024 оноос 2030 оныг дуустал төлөх төлбөрийг олон улсад ДОХ, гепатит, сүрьеэ өвчний эсрэг төсөл хэрэгжүүлдэг Глобаль санд төлж, эргээд тус байгууллага нь төлбөрийн дагуу хүлээн авсан хөрөнгийг Монгол Улсад эрүүл мэндийн төсөл хэрэгжүүлэхэд ашиглаж, Эрүүл мэндийн сайдад буцалтгүй тусламж хэлбэрээр олгох нөхцөлтэй болно.

3.4 Өрийн удирдлагын санхүүгийн шинжилгээний нэгдсэн системийг сайжруулж, мэдээллийн нэгдсэн санг шинэчлэх нөхцөлийг бүрдүүлэх;

Засгийн газрын өрийн өгөгдлийн сан бүрдүүлэх, өрийн үйлчилгээ, ашиглалт, шинээр гаргалт, гэрээний мэдээллийг тухай бүр бүртгэх зорилгоор НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)-аас боловсруулсан Өрийн удирдлага, санхүүгийн шинжилгээний систем (ДМФАС)-ийг 2005 оноос ашиглаж байна. Энэхүү систем нь зээллэгийн хэлэлцээрийн үеэс эхлэн төлж барагдуулж дуусах хүртэл бүх бүртгэлийг хийх боломжтой болгодог бөгөөд Сангийн яамнаас тус системийн эрхийг авч тухай бүр шаардлагатай хөгжүүлэлтийг хийж байна.

Түүнчлэн стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаанд ДМФАС системийн нэмэлт хөгжүүлэлт болох Өрийн удирдлагын санхүүгийн шинжилгээний дэд систем DMS-ийг боловсруулан 2024 оны 06 дугаар сард ашиглалтад оруулсан байна. Энэхүү системийг ашигласнаар төрийн өмчит байгууллагуудын санхүүгийн тайлангийн мэдээллийг нэгтгэж улсын секторын өрийн бүртгэлийг хийх боломжтой болгож байгаа бөгөөд Засгийн газрын өрийн зардал эрсдэлийн үзүүлэлтүүдийг тооцох, өрийн үйлчилгээний хуваарийг татан хуваарьт хугацаанд санхүүжилтийн мэдэгдлийг боловсруулах зэрэг өрийн мэдээллийн санг илүү өргөн цар хүрээтэйгээр бүрдүүлэх боломжийг бий болгож байна.

3.5 Орон нутгийн засаг захиргааны өрийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлээс сэргийлэх, Засгийн газрын өрийн мэдээллийн нэгдсэн санг хөтлөх талаар хамтран ажиллах.

Засгийн газрын 2024 оны 168 дугаар тогтоолоор “Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх” журмыг баталж, орон нутгаас үнэт цаас гаргахтай холбоотой асуудлыг зохицуулсан. Энэхүү журамд аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах процесс, тавигдах шаардлага болон хяналтын талаар туссан.

Түүнчлэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2024 онд 798.0 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаас, 500 сая ам.долларын гадаад үнэт цаасыг гаргаад байна. Түүнчлэн, Засгийн газрын 2025 оны 43 дугаар “Аймгийн үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох тухай” тогтоолын дагуу Даланзадгадад 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барих төслийн төслийг санхүүжүүлэх зорилгоор 500.0 тэрбум төгрөг хүртэлх аймгийн үнэт цаас гаргах зөвшөөрөл олгосон. Үнэт цаас гаргах хэмжээ нь 2026 онд 150.0 тэрбум төгрөг, 2027 онд 300.0 тэрбум төгрөг, 2028 онд 50.0 тэрбум төгрөг байна. Засгийн газрын 2026 оны зээллэгийн төлөвлөгөөнд тухайн үнэт цаасыг тусгаад байна.

Мөн орон нутгийн өрийн мэдээллийг өрийн мэдээллийн нэгдсэн санд бүрдүүлэх зорилгоор “Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх журам”-ын дагуу улирал бүр холбогдох орон нутгийн Засаг даргын Тамгын газруудаас мэдээллийг цуглуулж ДМФАС системд бүртгэн ажиллаж байна. Энэ хүрээнд Засгийн газрын өрийн нэгдсэн мэдээллийг ДМФАС системд орон нутгийн өрийн мэдээллийг бүртгэх, тайлагнах талаар сургалтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 12 дугаар сард орж, Нийслэлийн үнэт цаасны мэдээллийг хамтран тус системд бүртгэсэн.

Зорилт 4. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна.

4.1 Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд орчин үеийн дэвшилтэт технологийг ашигласан арилжааны систем нэвтрүүлэх;

Засгийн газраас 2023 оноос эхлэн Монголын Хөрөнгийн биржтэй хамтран Засгийн газрын үнэт цаасны нээлттэй зах зээлийн арилжаа явагдах bond.mse.mn системийг хөгжүүлж, 2025 оны 2 дугаар улирлаас эхлэн хоёр долоо хоног тутам үнэт цаасны арилжаа тогтмол явагдаж байна. Засгийн газрын дотоод үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангах хүрээнд үнэт цаасны дотоодын зах зээлд оролцогч хөрөнгө оруулагчдаас ЗГДҮЦ-ны зах зээлийн эрэлт болон хүлээлтийн талаарх тандан судалгааг 2024 оны 10 дугаар сарын 30-аас 11 дүгээр сарын 01-ний хооронд цахимаар хийсэн. Судалгаанд нийт 29 нь оролцогчоос хариу ирүүлснээс 9 арилжааны банк, 14 үнэт цаасны компани, 3 хувь хүн, 1 андеррайтер, 1 брокер, 1 ББСБ байна. Тус системээр 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 148.7 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаасыг арилжаалсан байна.

Тус системд ЗГДҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааг нэгдсэн болон ялгавартай үнээр явуулахаар хийгдсэн бөгөөд ЗГДҮЦ гаргах арилжааны мэдэгдэл, үр дүнгийн талаарх мэдээллийг авах боломжтой юм. Арилжааны төрлийг хямдруулалттай, тогтмол хүүтэй, өрсөлдөөнт арилжаа гэж тодорхойлсон бөгөөд нэг хөрөнгө оруулагчийн ЗГДҮЦ авах дээд хэмжээг хязгаарлах боломжийг багтаасан болно. Түүнчлэн, хадгаламж, төлбөр тооцоо гүйцэтгэгч болох “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”-тэй системт нь холбогдож ЗГДҮЦ гаргах бэлтгэл ажлыг хангаж байна. Энэхүү систем нь bond.mse.mn домайн хаягт байршиж байгаа болно.

Тухайн систем нь үнэт цаасны эргэн төлөлтийн хэмжээг бодож хөрөнгө оруулагчдад хүргүүлдэг тул эргэн төлөлтөд зөрүү үүсэх эрсдэлийг бууруулсан. Энэ нь 2017 он хүртэл ашиглагдаж байсан системээс арилжаа зохион байгуулах үйл ажиллагаа бүрэн автомат болж, үнэт цаасны хуваарилалт шууд хийгддэг. Мөн хөрөнгө оруулагчид арилжаа бүрийн мэдээлэл болон төлбөрийн тооцооллыг нэгдсэн байдлаар системээс тухай бүр хураангуй байдлаар харах боломжтой болсон.

4.2. Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч арилжаанд оролцсоноор бий болох үр ашиг, эрсдэлийн талаар иргэн, аж ахуйн нэгжсийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэн хөрөнгө оруулагчдын бааз суурийг нэмэгдүүлэх;

Хөрөнгө оруулагчдад Засгийн үнэт цаасны нээлттэй зах зээлийн арилжааны тухай мэдээллийг хүргэх зорилгоор “Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааны гарын авлага”-ыг боловсруулж, bond.mse.mn болон Сангийн яамны цахим хуудсанд арилжаа эхлэхээс өмнө байршуулсан.

Үүний үр дүнд 2025 оны 04 дүгээр сарын 16-нд нээлттэй арилжааг эхлүүлснээс 2025 оны 12 дугаар сарын 24-ийг хүртэл 32 удаагийн арилжааг зохион байгуулснаас давхардсан

тоогоор 237 хөрөнгө оруулагч оролцож 425 саналыг ирүүлсэн. ЗГДҮЦ-ны 71.7 хувийг арилжааны банк, 9.9 хувийг даатгалын байгууллага, 18.5 хувийг гадаад дотоодын иргэд, аж ахуй нэгж эзэмшиж байна. Мөн үнэт цаасны анхдагч болон хоёрдогч арилжаанд оролцсоноор бий болох үр ашиг, эрсдэлийн талаар иргэн, аж ахуйн нэгжийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгын хүрээнд 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр, 2025 оны 09 дугаар сарын 02-ны өдөр, 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр уулзалтуудыг хийсэн байна. Мөн ил тод байдлыг сайжруулахын тулд Сангийн яамны албан ёсны цахим хуудсанд арилжааны хуваарь, мэдэгдэл, үр дүн зэрэг мэдээллийг тогтмол хүргэж байна.

4.3. Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжаанд оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх, хоёрдогч зах зээл дэх үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор Засгийн газрын дотоод үнэт цаасыг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авах, зориотот зах зээлд чиглэсэн Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг зохион байгуулах дэд бүтэц болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх;


ЗГДҮЦ-ны арилжаанд Өрийн удирдлагын хууль болон Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйлчилгээний журмыг удирдлага болгон ажилладаг. Үүнд нэр томъёоны тодорхойлолт, үнэт цаас гаргагчийн чиг үүрэг, арилжаа эрхлэгч этгээдийн чиг үүрэг, шууд, шууд бус, бусад оролцогчийн чиг үүрэг, анхдагч зах зээлийн ерөнхий зарчим, арилжааны хуваарь, мэдэгдэл, төлбөр, тооцоо, бүртгэл, хоёрдогч зах зээлийн арилжааны зарчим, үнэт цаасыг буцаан худалдан авах, хугацаа сунгах, нөхцөл тогтоох зэрэг үйл ажиллагаа багтдаг болно. Жижиг хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэхийн тулд Сангийн сайдын 2025 оны 122 дугаар тушаалаар ЗГДҮЦ-ны батлагдсан аргачлалд нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүнд: Дараах өөрчлөлтүүдийг оруулсан байна.

- Өрсөлдөөнт бус саналд шууд оролцогчдоос ирүүлсэн 500 хүртэлх нэгж үнэт цаасыг шууд хуваарилах бөгөөд үлдсэн санал дээр нь хувь тэнцүүлэн хуваарилна.
- Арилжаанд оролцож буй нэг оролцогчид хуваарилах дээд хэмжээг хязгаарласан.
- Шууд болон шууд бус оролцогчид арилжаалахаар зарласан ЗГДҮЦ-ны 25-аас илүүгүй байхаар зохицуулсан.
- “Засгийн газрын 2024 зээллэгийн төлөвлөгөө” батлах тухай Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 71 дүгээр тогтоолд дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дээрх арилжааны шимтгэлийг бууруулахаар заасан. Үүний дагуу Монголын хөрөнгийн биржтэй хийсэн гэрээний дагуу үнэт цаас гаргагчаас 0.05 хувийн шимтгэл авах бол Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй хийсэн гэрээний дагуу үнэт цаас хадгалуулагчаас үнийн дүнгийн 0.02 хувийн шимтгэл авахаар байна. Түүнчлэн тус байгууллагууд нь хөрөнгө оруулагчаас шимтгэл авахгүй байхаар зохицуулсан байна.

4.4. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгийн зах зээл дэх жиншиг хүүгийн түвшнийг тогтоох зорилгоор жил бүр шинээр гаргах Засгийн газрын дотоод үнэт цаасны 10-20 хүртэлх хувийг урьдчилан зарласан хугацаа, нөхцөл бүхий хуваарийн дагуу арилжаа зохион байгуулагдахаас 3 сарын өмнө олон нийтэд нээлттэй зарлаж, хуваарийн дагуу үнэт цаасны арилжааг зохион байгуулах замаар арилжааг тогтмолжуулах.

Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журмын 9 дүгээр зүйлийн 9.4-т “ЗГДҮЦ-ны арилжааны хуваарийг үнэт цаас гаргагч, арилжаа эрхлэгч этгээдийн цахим хуудсаар болон бусад сувгаар, шаардлагатай тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан арилжааны хуваарьт туссан эхний арилжааны өдрөөс ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө олон нийтэд мэдээлнэ.” гэж заасны дагуу арилжааны хуваарийг улирал тутам батлуулдаг. Сангийн сайдын 2025 оны 51 дүгээр тушаалаар 2 дугаар улирлын хуваарь, 2025 оны 115 дугаар тушаалаар 3 дугаар улирлын хуваарь, 2025 оны 151 дүгээр тушаалаар 4 дүгээр улирлын хуваарийг тус тус баталсан байна. Засгийн газрын нээлттэй үнэт цаасны арилжааг хоёр долоо хоног тутам зохион байгуулдаг бөгөөд арилжаа хийгдэж эхэлснээс хойш богино буюу 6-12 сарын хугацаат үнэт цаасны өгөөж дунджаар 9.33 хувь, дунд хугацаат буюу 2-5 жилийн хугацаат үнэт цаасны өгөөж 11.17 хувь, урт хугацаат буюу 7 жилийн хугацаатай үнэт цаасны өгөөж 13.26 хувь байна. Цаашид мөн энэхүү арилжааг үргэлжлүүлж тогтмол арилжааг хийж дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжих, аж ахуйн нэгжүүдэд хямд өртгөөр санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

График 4. Засгийн газрын дотоод үнэт цаасны өгөөжийн муруй, 2025 оны жилийн эцсийн байдлаар



Зорилт 5. Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангаж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг хязгаарлана.

5.1 Эдийн засаг болон нийгмийн үр өгөөж өндөртэй төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан, "Шинэ сэргэлтийн бодлого"-д нийцсэн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрт Засгийн газрын өрийн баталгаа гаргах замаар дэмжлэг үзүүлэх;

УИХ-ын 2023 оны “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” 90 дүгээр тогтоолоор МУХБ-ны 70 сая ам.долларын зээлээр хэрэгжиж буй “Чойбалсан ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төсөл”-д 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр өрийн баталгаа гаргасан. Уг төсөл хэрэгжсэнээр Дорнод, Сүхбаатар аймгийн 36 сум, багийн 25,139 айл өрх, 3,133 аж ахуйн нэгж, албан байгууллага, уул уурхайн 13 ордын олборлох үйлдвэрүүдийг тасралтгүй, найдвартай эрчим хүчээр хангагдах юм. Түүнчлэн зүүн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа “Петрочайна дачин тамсаг” ХХК, “Цайрт минерал” ХХК, “ХХЕМ” ХХК, “Эм Эл Цахиурт овоо” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа төслүүдийн өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэгцээг хангахын зэрэгцээ цаашид төлөвлөсөн бүтээн байгуулалтын төслүүдийн эрчим хүчний хэрэгцээг байгаль орчинд ээлтэй технологи бүхий дотоодын эх үүсвэрээс бүрэн хангах ач холбогдолтой юм.

Монгол Улсын Хөгжлийн банкны 2022 оны санхүүгийн аудитлагдсан тайлангаар банкны “тогтвортой санхүүжилтийн харьцаа” 37.8% байсан нь Монголбанкнаас тогтоосон шаардлагыг хангаагүй. Энэ нь Монгол Улсын Хөгжлийн банкны олон улсын зах зээлд гаргасан 500.0 сая ам.долларын Евробонд болон Япон Улсын зах зээлд Засгийн газрын баталгаатай гаргасан 30.0 тэрбум иенийн бондын хугацаа энэ оны 4 дүгээр улиралд дуусах хуваарийн дагуу урт хугацаат санхүүжилтийн дүн буурсантай холбоотой. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй байх нь Зээлийн гэрээний хүрээнд үүргийн зөрчил үүсэж, улмаар Хятадын Хөгжлийн банк зээлийг хугацаанаас өмнө дуудах эрсдэл үүссэн бөгөөд нэмэлт санхүүжилтийг ашиглах боломжгүй болсон.

Иймд үүссэн нөхцөл байдлыг харгалзан Монгол Улсын Хөгжлийн банкны зүгээс ирүүлсэн хүсэлт, өндөр ач холбогдол бүхий стратегийн төслийг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах эдийн засгийн зайлшгүй хэрэгцээ шаардлагын үүднээс Монгол Улсын Хөгжлийн банканд Засгийн газрын өрийн баталгаа гаргах шийдвэр гарсан.

Түүнчлэн, 2025 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Зам тээврийн яамнаас “Нэгдүгээр тойрог зам” төслийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах хүсэлтийг ирүүлж, үүнд эрсдэлийн үнэлгээг боловсруулан Улсын Их Хурлаар хэлэлцүүлж 2025 оны 86 дугаар тогтоолоор зөвшөөрөл авсан. Гэсэн хэдий ч уг төслийн санхүүжилт шийдвэрлэгдээгүй гэх шалтгаанаар Засгийн газрын өрийн баталгааг 2025 оны төсвийн жилд багтаан гаргаагүй.

5.2 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гаргах Засгийн газрын өрийн баталгаанаас төсөвт үүсээж болзошгүй эрсдэлийг үнэлэх, эрсдэлээс сэргийлэх чиглэлээр өрийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, бүртгэл хөтлөх, тайлагнах механизмыг бүрдүүлэх;

Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 474 дүгээр тогтоолын хавсралтаар “Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын баталгаа гаргах журам”-ыг баталсан. Үүний хүрээнд Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн улсын төсөвт үзүүлэх дарамтыг тооцох, эрсдэлийг үнэлэх механизмыг гаргасан.

Түүнчлэн, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд төрөөс үзүүлэх дэмжлэг болох хөрөнгө оруулалт, эх үүсвэрийг улсын төсвөөс шийдвэрлэх, мөн төрөөс хариуцах газрын зөвшөөрөл, татварын хөнгөлөлт, худалдан авалт болон бусад асуудлыг тусгасан болно. Улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл тооцох загварыг Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан бөгөөд үүнийг Дэлхийн банкны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөвт үзүүлэх эрсдэлийн үнэлгээний загварыг ашиглаж боловсруулсан.

5.3 Засгийн газрын өрийн баталгаа гаргасан төслүүдийн эргэн төлөлт, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах;

Засгийн газрын өрийн баталгаат зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих зорилгоор эргэн төлөлт, үлдэгдлийн мэдээллийг авч Засгийн газрын өрийн статистикийн мэдээ гаргахад ашиглаж байна. “Эрдэнэс Монгол” ХХК-аас Азийн хөгжлийн банкнаас авч ашигласан Засгийн газрын өрийн баталгаатай зээлийн төлбөрийг хугацаанаас өмнө буюу 2024 оны 10 дугаар сард эргэн төлж 2031 онд дуусах нөхцөлтэй зээлийг бүрэн төлж барагдуулсан.

Түүнчлэн, Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг удирдах, хяналт тавих зорилгоор тайлант хугацаанд Засгийн газрын өрийн баталгаатай зээллэг хийсэн байгууллагуудад 2023-2025 онуудад жил бүр эрсдэлийн үнэлгээг хийн Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

5.4 Төсвөөс шууд төлөгдөх нөхцөлтэй Барих-Шилжүүлэх төрлийн концессын гэрээ байгуулахгүй, өрийн бичиг /вексель/ шинээр гаргахгүй байх

Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр баталсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт “барих-шилжүүлэх” төрлийн түншлэлийн гэрээг байгуулах болон түншлэлээр хэрэгжүүлэхийг хориглохоор тусгасан.

Энэ хүрээнд Засгийн газраас шинээр Барих-Шилжүүлэх нөхцөлтэй концессын төрлийн гэрээ байгуулаагүй бөгөөд өрийн бичиг /вексель/ гаргаагүй болно.

Зорилт 6. Засгийн газрын өрийн удирдлагын нл тод байдлыг сайжруулна.

6.1 Улирал бүр Засгийн газрын өрийн товхимлыг олон нийтэд ил тод мэдээлэх

Засгийн газрын өрийн статистикийн товхимлыг улирал бүр бэлтгэн Сангийн яамны цахим хуудсанд олон нийтэд ил тод байдлаар улирал бүр байршуулж байна. Энэхүү

товхимлыг Сангийн яамны цахим хуудаснаас харах боломжтой бөгөөд үүнд Засгийн газрын өрийн үлдэгдэл, бүтцийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг оруулдаг.

Холбоос:<https://mof.gov.mn/article/zasgiin-gazriin-uriin-medeelel-2/zasgiin-gazriin-uriin-medeelel-3/>

6.2 Улсын секторын өрийн мэдээллийг олон улсын байгууллагаас тогтоосон нэгдсэн стандартын дагуу бэлтгэж, мэдээлэх

Улсын секторын өр гэдэг нь Засгийн газар болон төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан санхүүгийн бус салбарын ААН-үүдийн улсын сектороос бусад ААН-үүдийн өмнө хүлээсэн төлбөрийн үүрэг юм.

Тус мэдээллийг хагас жил тутам тайлагнадаг бөгөөд 2023 онд 12 санхүүгийн байгууллага, 2024 онд 62 санхүүгийн байгууллага, 2025 онд 83 санхүүгийн байгууллагын мэдээллийг Сангийн яамнаас боловсруулсан DMS системээр цуглуулж, ОУВС-ын стандартын дагуу бүртгэж, Сангийн яамны цахим хуудсанд байршуулсан байна. Түүнчлэн, санхүүгийн тайлагналыг сайжруулж, нэгдсэн загвар үүсгэхийн тулд E-balance системд байгууллагуудын мэдээллүүдийг тулган баталгаажуулдаг.

DMS систем дээр байгууллагуудын тайланг богино, урт дунд хугацаагаар ангилан төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж ба улсын төсөвт өгөх өр төлбөр, Монгол Улсад бүртгэлтэй, дотоодын хувийн аж ахуйн нэгжийн өр төлбөр болон гадаадын аж ахуйн нэгж, олон улсын санхүүгийн байгууллагад төлөх өр төлбөрийг ялган бүртгэдэг бөгөөд үүнд зээл, үнэт цаас, урьдчилж олсон орлого болон бусад өр төлбөрүүдийг багтааж байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАГЦЫН ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТОТ БҮТЭЦ, ЗАРДАЛ ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ,

Засгийн газрын өрийн багцад хийсэн зардал эрсдэлийн шинжилгээний үр дүнг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 7. Засгийн газрын өрийн багцын зардал эрсдэлийн шинжилгээний үр дүн

Үзүүлэлт	Түвшин	2023*	2024*	2025*
Өрийн зардал				
Жигнэсэн дундаж хүү (хувь)	Гүйцэтгэл	3.5	4.3	3.4
	Дээд	3.8	4.3	4.8
Дахин санхүүжилтийн эрсдэл				
Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа /жил/	Гүйцэтгэл	7.9	7.5	7.2
	Доод	7.8	7.3	6.8
Хүүгийн эрсдэл				
Засгийн газрын өрийн хүүгийн түвшин шинэчлэгдэх дундаж хугацаа /жил/	Гүйцэтгэл	7.1	6.5	6.3
	Доод	7.0	6.5	6.3
Ханшийн эрсдэл				
Гадаад валютаар илэрхийлсэн өр /нийт өрд эзлэх хувь/	Гүйцэтгэл	98.4	96.1	95.9
	Дээд	80.0	80.0	80.0

*-Засгийн газрын өрийн баталгааг оруулж тооцоогүй болно.

3.2.1 Өрийн зардал

Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаанд буюу 2023-2025 онд хүүгийн түвшин өндөр Засгийн газрын дотоод үнэт цаас арилжаалаагүй бөгөөд хөнгөлөлттэй зээлээр төсвийн алдагдлыг нөхөх, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх бодлого баримталсан.

Түүнчлэн, 2023-2024 онуудад олон улсад тулгарсан инфляцын өсөлтөөс шалтгаалж улс орнууд бодлогын хүүгээ өсгөсөнтэй холбоотойгоор гадаад зээлийн жишиг хүү болох Баталгаат овернайт хүүгийн түвшин түүхэн дээд хэмжээнд хүрч Засгийн газрын нийт өрийн 65 хувийг эзэлж буй гадаад зээлийн дундаж хүүгийн түвшин өссөн, мөн гадаад үнэт цаасны жишиг хүүгийн түвшин болох АНУ-ын Холбооны нөөц банкны бондын өгөөж өссөнтэй холбоотойгоор 2023 онд шинээр гаргасан үнэт цаас болох “Сенчири-2” болон “Сенчири-3” бондуудын хүүгийн түвшин өндөр байсантай холбоотойгоор гадаад үнэт цаасны хүүгийн түвшин өссөн байна.

Харин 2025 онд АНУ-ын төв банк хөдөлмөрийн зах зээлийн өсөлтийг дэмжих зорилгоор бодлогын хүүг бууруулснаар Баталгаат овернайт хүүгийн түвшин 2025 оны эхэнд 4.31 хувь байсан бол 2025 оны эцэст 3.87 хувь болж буурснаар засгийн газрын гадаад зээлийн хөвөгч хүүтэй эх үүсвэрээр санхүүжсэн санхүүжилтийн зардал буурсан байна. Мөн АНУ-ын ерөнхийлөгч Дональд Трамп татварын хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргахаас өмнө эдийн засгийн орчин таатай үед 6.625 хувийн хүүтэй Сенчири-4 бондыг олон улсын

зах зээлд арилжаалж, 8.650 хувийн хүүтэй Сенчири-2 бондын тодорхой хэсгийг дахин санхүүжүүлснээр гадаад үнэт цаасны өрийн зардал буурсан байна.

Ингэснээр Засгийн газрын өрийн жигнэсэн дундаж хүүгийн түвшин 2023 онд 3.5 хувь, 2024 онд 4.2 хувь, 2025 онд 3.4 хувьтай тус тус тэнцээд байна.

3.2.2 Дахин санхүүжилтийн эрсдэл

Монгол Улсын эдийн засгийн хувьд Дэлхийн банкны аргачлалаар дунджаас дээд түвшинд хүрч, олон улсын санхүүгийн байгууллагууд хугацаа өндөр буюу 30-40 жилийн хугацаатайгаар олгодог байсан зээлийг 10-25 жилийн хугацаатай олгож эхэлсэн, мөн Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт улсын төсвийн орон зайнаас шалтгаалж удааширч байгаатай холбоотойгоор Засгийн газрын гадаад зээлийн эргэн төлөгдөх дундаж хугацаа буурч байна.

Ингэснээр Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа 2023 онд 7.9 жил, 2024 онд 7.5 жилтэй тэнцэж байсан бол 2025 онд 7.2 жилтэй тэнцэж буурсан байна.

3.2.3 Хүүгийн эрсдэл

Монгол Улс дундаас дээш орлоготой орны ангилалд шилжсэн болон олон улсын байгууллагуудаас тогтмол хүүтэй санхүүжилтийн эх үүсвэрийг хөвөгч хүүтэй эх үүсвэрт шилжүүлснээс шалтгаалж, гадаад зээлийн ашиглалтын ихэнх хувийг хөвөгч хүүтэй зээл эзэлж байгаа тул Засгийн газрын өрийн хүү шинэчлэгдэх дундаж хугацаа 2023 онд 7.1 жил, 2024 онд 6.5 жил болж буурсан байна. Мөн 2025 онд Баталгаат овернайт хүүгийн түвшин буурсан ч, хөвөгч хүүтэй зээлийн засгийн газрын өр төлбөр дэх хэмжээ өөрчлөгдөөгүй тул хүү шинэчлэгдэх дундаж хугацаа 2025 онд 6.3 жил болж буурсаар байна.

3.2.4 Ханшийн эрсдэл

Ханшийн эрсдэлийг тооцоход Засгийн газрын өрийн үзүүлэлтэд төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор авсан зээлүүд, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан хаалттай хэлбэрээр арилжаалсан үнэт цаас болон ЗГДҮЦ-ны зах зээлийг дэмжих зорилгоор арилжаалсан нээлттэй хэлбэрээр арилжаалсан дотоод үнэт цаас, дахин санхүүжүүлэх зорилгоор гадаад үнэт цаас болон орон нутгийн үнэт цаасыг багтаасан.

Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг 2017 оноос эхлэн зогсоосноор Засгийн газрын дотоод үнэт цаасны хэмжээ 2024 онд 231.4 тэрбум төгрөгт хүрч буурчээ. Улмаар гадаад валютаар илэрхийлсэн өрийн дотоод, гадаад өрд эзлэх хэмжээ 2023 онд 98.4 хувьд хүрсэн нь байна. Харин 2024 онд хаалттай хэлбэрээр Нийгмийн даатгалын санд 300.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг арилжаалснаар Засгийн газрын дотоод үнэт цаасны хэмжээ 400.5 тэрбум төгрөгт хүрч, гадаад валютаар илэрхийлсэн өрийн дотоод, гадаад өрд эзлэх хэмжээ 96.1 хувьд хүрсэн байна. Сангийн сайдын 2025 оны 51 дүгээр тушаалаар Засгийн газрын дотоод үнэт цаасны нээлттэй арилжааг 2025 оны 2 дугаар улирлаас эхлүүлснээр засгийн газрын дотоод үнэт цаасны өрийн хэмжээ 688.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Улмаар гадаад валютаар илэрхийлсэн өрийн хэмжээнд өрд эзлэх хувь 95.9 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар буурсан байна.